

**Монголын нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгэмлэг– 2007- 2015 оны Стратеги төлөвлөгөө**

**Зорилго:** Монгол улсын эрүүл мэндийн хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд нь нотолгоонд суурилан бодитой хэрэгжиж зохицуулах эрх бүхий хяналтын байгууллагууд нь үүргээ хариуцлагатай гүйцэтгэдэг болох

**Зорилт:** Нийгмийн эрүүл мэндийн нотолгоонд тулгуурласан бодлого хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд идэвхитэй оролцож олон нийтийн оролцоог дэмжих

Стратеги	Үйл ажиллагааны чиглэл	Хамтрагч талууд	Давтамж, хүрэх үр дүн
1. Бодлого, хөтөлбөр боловсруулах хэлэлцүүлэг, зөвшилцөлд идэвхитэй оролцох (засгийн газар, олон салбарын, хандивлагчдын зохион байгуулсан)	1.1 Хэлэлцүүлэгт идэвхтэй оролцох (урилгаар) 1.2 Бодлогын хэлэлцүүлэгт оролцох замаар нөлөөллийн үйл ажиллагаа идэвхитэй явуулах	<ul style="list-style-type: none"> <li>Төрийн захиргааны төв байгууллагууд (эрүүл мэнд, нийгэм хамгаалал, боловсрол, байгаль орчин, хууль зүй)</li> <li>Төрийн байгууллагууд, хяналтын байгууллагууд, хүрээлэнгүүд (тухайлбал ЭМХҮТ, УМХГ, НЭМХ)</li> <li>Хэрэглэгчид</li> <li>Төрийн бус байгууллагууд</li> <li>Мэргэжлийн нийгэмлэгүүд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хэлэлцүүлэгт оролцох – тогтмол</li> <li>Бодлогын хэлэлцүүлэгт нийгэмлэгийг оролцуулах замаар нөлөөллийн үйл ажиллагаа явуулах- тогтмол</li> <li>Жилд 1-ээс доошгүй удаа бодлогын чиглэлээр бие даасан мэдэгдэл гаргаж байна.</li> </ul>
2. Бодлогын чиглэлээр хэлэлцүүлэг, мэтгэлцээн хийх боломжийг нээлттэй болгох замаар бие даасан үйл ажиллагаа явуулах	2.1 Бусад салбарын түнш байгууллагуудтай зөвлөлдсөний үндсэн дээр эрүүл мэндийн болон нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлуудаар бодлогын чанартай бие даасан мэдэгдэл боловсруулан нийтийн хүртээл болгох. 2.2 Эрүүл мэндийн салбарын бусад байгууллагуудын чиг үүргийг харгалзан зохих дэмжлэг үзүүлэх. 2.3 Эрүүл мэндийн яам болон олон талт хамтын ажиллагаа явуулдаг хандивлагч байгууллагууд бодлого боловсруулах үйл явцдаа хамтрагч талуудын өргөн хүрээтэй оролцоог хангах албан ёсны байнгын механизмтай болох		<ul style="list-style-type: none"> <li>Жилд 1-ээс доошгүй удаа олон нийтэд чиглэсэн кампанит ажил зохион байгуулна (тухайлбал НҮБ-ээс зарласан эрүүл мэндийн өдрүүдээр)</li> <li>Жилд 1-ээс доошгүй удаа</li> </ul>
3. Бодлогын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж, зохицуулах эрх бүхий хяналтын байгууллагуудын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх	3.1 Нийгмийн эрүүл мэндийн хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, дүрэм журмуудын талаар олон нийтийн ойлголтыг сайжруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх (олон нийтийн оролцоо хэсгийг үзнэ үү) 3.2 Нийгмийн эрүүл мэндийн хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, дүрэм журмуудын		<ul style="list-style-type: none"> <li>Жилд 1-ээс доошгүй удаа олон нийтэд чиглэсэн кампанит ажил зохион байгуулна (тухайлбал НҮБ-ээс зарласан эрүүл мэндийн өдрүүдээр)</li> <li>Жилд 1-ээс доошгүй удаа</li> </ul>

Стратеги	Үйл ажиллагааны чиглэл	Хамтрагч талууд	Давтамж, хүрэх үр дүн
<p>4. Бодлого боловсруулах үйл явцад олон нийтийн оролцоог хангах</p> <p>5. Бодлогыг нотолгоонд суурилан боловсруулахад хувь нэмрээ оруулах үүднээс судалгаа шинжилгээний чадавхийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх</p>	<p>хэрэгжилтийг хангах чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагаа явуулах</p> <p>4.1 Нийгмийн эрүүл мэндийн бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд үнэлгээ хийх</p> <p>4.2 Үйл ажиллагааны чиглэл тус бүрээр иргэний нийгмийн ашиг сонирхлыг илэрхийлэгч дотоодын ТББ-тай хамтын ажиллагаагаа хөгжүүлж, өргөжүүлэх</p> <p>4.3 Бодлого боловсруулах үйл явцад иргэний нийгмийн болон үйлчлүүлэгчдийн төлөөллийг оролцуулахыг идэвхитэй дэмжих</p> <p>4.3 Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нөлөөллийн үйл ажиллагааг явуулах</p> <p>5.1 Бодлогын зөвлөмж гаргах зорилгоор жижиг хэмжээний судалгаа явуулах санхүүгийн эх сурвалж хайх</p> <p>5.2 Гишүүд судалгааны ажлын үр дүнгээ олон улсын түвшинд танилцуулахыг дэмжих</p> <p>5.3 Судалгааны ажлын үр дүнг эрүүл мэндийн шинжлэх ухааны сэтгүүлд нийтлэхийг дэмжих</p> <p>5.4 Эрүүл мэндийн шинжлэх ухааны сэтгүүлүүдийн редакцийн зөвлөлийн бүрэлдэхүүнд нийгмийн эрүүл мэндийн бодлогын мэргэжилтнүүдийн төлөөллийг оруулахад нөлөөлөх үйл ажиллагаа явуулах</p> <p>5.5 Бодлогын судалгааг дэмжих, эрүүл мэндийн судалгааны нэгдсэн төлөвлөгөөтэй болохыг сурталчилсан нөлөөллийн үйл ажиллагаа явуулах</p> <p>5.6 Засгийн газарт нотолгоонд тулгуурласан бодлого боловсруулахад нөлөөлөх үйл ажиллагаа явуулах</p> <p>5.7 Эрүүл мэндийн сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих</p>		<p>хяналтын байгууллагуудтай хамтарсан арга хэмжээ зохион байгуулна</p> <ul style="list-style-type: none"> <li>• Жилд 1-ээс доошгүй удаа аль нэг бодлогын хэрэгжилтийг үнэлнэ.</li> <li>• Дотоодын ТББ-тай хамтын ажиллагаа хөгжүүлж, өргөжүүлэх – тогтмол</li> <li>• Холбогдох иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран жилд 1-ээс доошгүй удаа асуудал хөндсөн семинар зохион байгуулна</li> <li>• НЭММН-ийн хийсэн судалгааны ажлуудын үр дүнг судалгаа дууссанаас хойш 6 сараас 1 жилийн хугацаанд нийтлүүлж байна</li> </ul>

**Зорилго:** Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүдийн дэмжлэгтэйгээр Монгол улсын эрүүл мэндийн салбар нийгмийн эрүүл мэндийн чиг баримжаатай болсон байна.

**Зорилт:** Монгол улсын эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүдийн мэдлэг, чадварыг тасралтгүй дээшлүүлэх

Стратеги	Үйл ажиллагааны чиглэл	Хамтрагч талууд (өнөөгийн болон боломжит)	Давтамж, хүрэх түвшин
<p>1. Эрүүл мэндийн салбарын шийдвэр гаргах, тусламж үйлчилгээ үзүүлэх түвшинд ажиллаж буй мэргэжилтнүүдэд нийгмийн эрүүл мэндийн бүхий л чиглэлээр сургалт явуулах</p> <p>2. Эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг бэлтгэх төгсөлтийн өмнөх болон дараах сургалтын хөтөлбөрт нийгмийн эрүүл мэндийн асуудлыг тусгахад чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх</p> <p>3. Эрүүл мэндийн бус салбарын (хуульч, байгаль орчин, мал эмнэлэг гм) төгсөлтийн өмнөх болон дараах сургалтын хөтөлбөрт нийгмийн эрүүл мэндийн асуудлыг тусгахад чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх</p>	<p>1.1 Эрүүл мэндийн салбарт ажиллагсдын нэн ялангуяа шийдвэр гаргах түвшний болон анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэгчид, хөдөөгийн эрүүл мэндийн ажилтнуудын нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн сургалтын хэрэгцээг тогтоох (одоо байгаа мэдээллүүдийг тоймлон судлах замаар хэрэгжүүлж болно).</p> <p>1.2 Хэрэгцээнд нийцсэн сургалт зохион байгуулах</p> <p>3.1 Эрүүл мэндийн бус салбарын нийгмийн эрүүл мэндийн мэдлэг, чадварыг хөгжүүлэх чиглэлээр бусад мэргэжлийн нийгэмлэгүүдтэй хамтын ажиллагаагаа хөгжүүлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Эмнэлгүүд</li> <li>• Өрхийн эмнэлгүүд</li> <li>• Мэргэжлийн нийгэмлэгүүд</li> <li>• Аймгийн ЭМГ,</li> <li>• Бүсийн Оношлогоо Эмчилгээний Төв(БОЭТ)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• 2007/08 онд аль нэг аймгийг сонгон авч эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгмийн эрүүл мэндийн сургалтын хэрэгцээг тогтооно.</li> <li>• Эмч нарт зориулсан сургалтыг жилд 1-ээс доошгүй удаа Улаанбаатар хотод зохион байгуулна.</li> <li>• Эмнэлгийн бусад мэргэжилтнүүдэд зориулсан сургалтыг жилд 1-ээс доошгүй удаа Улаанбаатар хотод зохион байгуулна.</li> <li>• Жилд 1-ээс доошгүй удаа хөдөө орон нутагт сургалт зохион байгуулна .</li> </ul>

**Зорилго:** Монголын хүн ам эрүүл мэндийн хууль тогтоомж, дүрэм журам, эрүүл мэндийн эрсдлийг бууруулах, нийгмийн эрүүл мэндийн асуудлын талаар мэдлэгтэй болно.

**Зорилт:** Хүн амын эрүүл мэндийг дэмжихэд хувь нэмрээ оруулах

Стратеги	Үйл ажиллагааны чиглэл	Хамтрагч талууд	Давтамж, хүрэх түвшин
1. Сэтгүүлчид, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан нийгмийн эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа явуулах	1.1 Хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг сайжруулах үүднээс хэвлэл мэдээллээр сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах санхүүгийн дэмжлэг хайх 1.2 Нийгмийн эрүүл мэндийн асуудлууд, хууль дүрэм, эрүүл мэндийн эрсдэлтэй зан үйлийн талаар мэдлэг олгох замаар сэтгүүлчидтэй хамтран ажиллах	<ul style="list-style-type: none"> <li>• Төрийн захиргааны төв байгууллагууд (ЭМЯ, БСШУЯ гм)</li> <li>• Орон нутгийн захиргааны байгууллага, сургуулиуд</li> <li>• Хэвлэл мэдээллийн хэрэгсэл</li> <li>• Мэргэжлийн нийгэмлэгүүд</li> <li>• Хүн ам</li> <li>• Олон улсын ТББ (Дэлхийн зөн, Норвегийн тусламжийн байгууллага гм)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Бодлогын үйл явцад нөлөөлөх үйл ажиллагааны хөтөлбөрт сэтгүүлчдэд чиглэсэн арга хэмжээг нэгтгэн тусгана.</li> </ul>
2. Ерөнхий боловсролын сургуулиудын эрүүл мэндийн хичээл заахад дэмжлэг үзүүлэх	2.1 ЕБС-ийн эрүүл мэндийн сургалтын агуулгыг чанаржуулж хэрэгжүүлэх, багш нарын чадавхийг сайжруулах чиглэлээр засгийн газар болон олон улсын хандивлагч байгууллагуудтай хамтран ажиллах		<ul style="list-style-type: none"> <li>• 2007/08 онд хамтран ажиллах талуудаа тодорхойлон 2008 онд үр дүнтэй хамтран ажиллана.</li> </ul>
3. Эрүүл мэндийн бусад мэргэжлийн нийгэмлэгүүдтэй үйл ажиллагааны сүлжээ бий болгох	НҮБ-ээс хэрэгжүүлдэг дараах арга хэмжээнд оролцох: <ul style="list-style-type: none"> <li>• Дэлхийн эрүүл мэндийн өдөр (4 сар)</li> <li>• Замын аюулгүй байдлын өдөр (4 сар)</li> <li>• Дэлхийн тамхигүй өдөр (5 сар)</li> <li>• Дэлхийн эхийн сүүгээр хооллох долоо хоног (8 сар)</li> <li>• Сэтгэцийн эрүүл мэндийн өдөр (11 сар)</li> <li>• ДОХ-той тэмцэх Дэлхийн өдөр (12 сар)</li> </ul>		<ul style="list-style-type: none"> <li>• Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр бусад байгууллагаас хэрэгжүүлж буй арга хэмжээнд оролцох</li> </ul>
4. Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр бусад байгууллагаас хэрэгжүүлж буй арга хэмжээнд оролцох			

**Зорилго:** Нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд бусад салбарууд хамтдаа ажилладаг болно.

**Зорилт:** Монгол улсын хүн амыг эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйлсэд олон салбарын хамтын ажиллагааг бэхжүүлэх

Стратеги	Үйл ажиллагааны чиглэл	Хамтрагч талууд (өнөөгийн болон боломжит)	Давтамж, хүрэх түвшин
<p>1. Бусад салбарын байгууллагуудтай холбоо тогтоож нийгмийн эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэх,сайжруулах чиглэлээр хамтран ажиллах</p> <p>2. Нийгмийн эрүүл мэндийн нийтлэг асуудлуудаар бусад салбарын ТББ, мэргэжлийн нийгэмлэгүүдтэй хамтын ажиллагаагаа хөгжүүлэн, өргөжүүлэх</p> <p>3. МНЭМН-ийн хүрээг дотоодод болон олон улсын түвшинд өргөжүүлэх</p>	<p>1.1 Бодлогын хэлэлцүүлгүүдэд оролцох (урилгаар)</p> <p>1.2 Нийгмийн эрүүл мэндийн тэргүүлэх чиглэл болон түүний үр ашигт нөлөөлөх төлөвлөгөөний талаар бусад төрийн байгууллагуудтай уулзалт зохион байгуулах</p> <p>2.1 Эрүүл мэндийн байгууллагуудын сар тутмын уулзалтад тогтмол оролцох</p> <p>2.2 Монгол улсын эрүүл мэндийн салбарт үйл ажиллагаа явуулдаг бусад мэргэжлийн нийгэмлэгүүдтэй уулзаж, ашиг сонирхол нэгтэй бодлогын чиглэл тогтоох</p> <p>2.3 Бусад мэргэжлийн нийгэмлэгүүдтэй (хууль, байгаль орчин гм) уулзаж, ашиг сонирхол нэгтэй бодлогын чиглэл тогтоох</p> <p>3.1 Ололт амжилтаа тусгасан тайланг жил бүр монгол англи хэл дээр боловсруулан гаргах</p> <p>3.2 Төгсөлтийн өмнөх ба дараах сургалтад хамрагдаж буй оюутнуудад нийгэмлэгийн үйл ажиллагааг сурталчилах</p> <p>3.3 Нийгэмлэгийн Веб хуудсыг боловсруулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Өрхийн эмч нарын нийгэмлэг</li> <li>• Гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг</li> <li>• Хувийн эмнэлгүүдийн холбоо</li> <li>• Анагаах ухааны мэргэжлийн зөвлөл</li> <li>• Сувилагчдын нийгэмлэг</li> <li>• Эх баригчдын нийгэмлэг</li> <li>• Мал эмнэлгийн нийгэмлэг</li> <li>• Эмэгтэйчүүдийн ТББ-ын сүлжээ</li> <li>• Нийгмийн ажилтнууд</li> <li>• Сэтгэл зүйчид</li> <li>• Байгаль орчны мэргэжилтнүүд</li> <li>• Лабораторийн мэргэжилтнүүд</li> <li>• Инженерууд</li> <li>• Хуульчид</li> <li>• Хооллолтын мэргэжилтнүүд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Бодлогын хэлэлцүүлгүүдэд оролцоно - тогтмол</li> <li>• Холбогдох байгууллагуудтай жилд 1-ээс доошгүй удаа уулзаж байна.</li> <li>• 2007/08 онд Монгол улсын эрүүл мэндийн салбарт үйл ажиллагаа явуулдаг бусад мэргэжлийн нийгэмлэгүүдтэй ашиг сонирхол нэгтэй бодлогын чиглэл тогтоох уулзалтыг санаачлан зохион байгуулна</li> <li>• Эрүүл мэндийн салбарт үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн нийгэмлэгүүдтэй жил бүр уулзалт зохион байгуулна.</li> <li>• Нийгмийн эрүүл мэндийн салбар дундын тулгамдсан асуудал сонгон авч жил бүр холбогдох нийгэмлэгүүдтэй уулзалт зохион байгуулна (санхүүгийн асуудал, зохион байгуулагчийг шийдвэрлэх шаардлагатай)</li> <li>• Тайланг жил бүр гаргана</li> <li>• 2007 онд оюутнуудад сурталчлах семинарыг анх удаа зохион байгуулна.</li> <li>• Уг семинарыг тогтмолжуулна</li> <li>• Нийгэмлэгийн Веб хуудсыг 2007 онд боловсруулж үйл ажиллагааг нь тогтмолжуулна</li> </ul>

**Зорилго:** Нийгмийн эрүүл мэндийн өсөлт хөгжилтөд дэмжлэг үзүүлэх олон улсын хүчирхэг түнш байгууллагуудтай холбоо тогтоон хамтын ажиллагаагаа өргөжүүлэх

**Зорилт:** Монгол улсын хүн амыг эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйлсэд олон улсын түвшинд харилцаа холбоогоо өргөжүүлэн хөгжүүлэх

Стратеги	Үйл ажиллагааны чиглэл	Хамтрагч талууд	Давтамж, хүрэх түвшин
1. Ур чадвараа хөгжүүлэх, мэдээлэлээ солилцох, мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад дэмжлэг олох зорилгоор бусад орны нийгмийн эрүүл мэндийн нийгэмлэгүүдтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлэн, хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"><li>• Хамтран ажиллах боломжтой бусад орны нийгмийн эрүүл мэндийн нийгэмлэгүүдийг тодруулж хамтын ажиллагааны урт хугацааны төлөвлөгөө боловсруулан, материаллаг эх үүсвэрээ харилцан солилцох механизм бий болгох</li><li>• Дэлхийн Нийгмийн эрүүл мэндийн нийгэмлэгүүдийн холбооны гишүүн болох</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>• Соросын сүлжээний гишүүн хуучин Зөвлөлтийн холбооны улсууд</li><li>• Хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байсан олон улсын түншүүд</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>• 2007/08 бусад орны нийгэмлэгүүдтэй харилцаа холбоо тогтоож хамтын ажиллагааны урт хугацааны төлөвлөгөө боловсруулан боломжтой бүх чиглэлээр ажиллах</li></ul>